

	хэрэгжүүлэхэд зориулан төсөвлөж, зарцуулсан санхүүжилтийн өмнөх оныхтой харьцуулсан өсөлт		дахин	дахин	байгууллага
4	Жендэрийн асуудал хариуцсан ажилтан мэргэжилтэнтэй болон сургагч багштай болсон байгууллагын тоо	21	31	41	Бүх сум, байгууллага
5	Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн санал санаачилгыг сурталчилсан байдал (сургалт, бусад арга хэмжээ)	-	2	4	Бүх сум, байгууллага
6	Байгууллагын дэргэдэх гэр бүлийн зөвлөлөөр дамжуулан жендэрийн мэдрэмжтэй гэр бүлийн боловсролыг дэмжсэн байгууллага, клуб (тоо/хамрагдагсад)	-	5/100	10/200	ГБХЗХГазар Бүх сум, байгууллага
7	"Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн (хувиар)	-	40	70	ХХҮГазар Бүх сум, байгууллага
8	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг кабинет	-	1	1	ЭМГазар БОЭТөв
9	Жендэрийн тухай ойлголт, жендэрийн тэгш байдал, хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг үл тэвчих ойлголт, эерэг хандлагыг төлөвшүүлэх сургалтын тоо (хамрагдсан хүний тоо)	21/500	31/1000	41/2500	Бүх сум, байгууллага сургагч багш нар
10	Жендэрийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан (УА), төрийн албан хаагч (ТАХ)	УА-... хувь ТАХ-... хувь	УА-...хувь ТАХ-... хувь	УА-...хувь ТАХ-...хувь	Бүх сум, байгууллага сургагч багш нар
11	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн жендэрт суурилсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийн тоо	1	3	5	АЗДТГазар Хэвлэл мэдээллийн байгууллага
12	Хамтран ажилласан төрийн бус байгууллагын тоо	1	2	4	АЗДТГазар ИНБайгууллага
13	Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд ИНБ-аар хөндлөнгийн үнэлгээ, мониторинг хийлгэсэн байдал/тайлан	1	1	2	АЗДТГазар ИНБайгууллага
14	Хамгаалах байрын тоо	1	1	1	ГБХЗХГазар

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

1. Улсын болон орон нутгийн төсөв
2. Орон нутгийн хөтөлбөрийн санхүүжилт
3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт, үнэлгээ

1. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлан, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжин хамтран ажиллана

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллах, олон нийтэд мэдээлэх үүргийг Жендэрийн аймгийн салбар хороо хариуцана.

3. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.

4. Орон нутаг дахь төрийн бус байгууллагууд нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг идэвхжүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийлгэнэ.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 13

Арвайхээр

“Жендэр-ӨВ дэд хөтөлбөр”
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жендэр эрх тэгш байдлыг хангах “Жендэр-ӨВ дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Жендэр-ӨВ дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлах, хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Ганболд/-д даалгасугай.


ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн
2019 оны 03 дугаар сарын 12 -ны өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт

**“ЖЕНДЭР-ӨВ” ДЭД ХӨТӨЛБӨР
/2019-2021/**



Нэг. Үндэслэл

Өвөрхангай аймгийн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр нь (Цаашид “Жендэр-ӨВ” дэд хөтөлбөр гэх) Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр заалт, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авах тухай Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолд үндэслэв.

Дэд хөтөлбөр боловсруулах хүрээндээ “Өвөрхангай аймгийн жендэрийн нөхцөл байдлын судалгааны дүн шинжилгээ” үнэлгээг аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын холбооны нэгдсэн сүлжээний тэргүүлэгч “Эх нутаг төв” төрийн бус байгууллага удирдан иргэний нийгмийн байгууллагууд хамтран 2018 оны 10-11 дүгээр сард аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг, зарим байгууллагын стратегийн бодлогын баримт бичиг, хөдөлмөрийн дотоод журам, бүх шатанд байгуулсан гэрээнүүд болон аймгийн ИТХурлын тогтоолоор хүчин төгөлдөр хэрэгжиж буй 23 төрлийн бодлогын баримт бичигт жендэрийн эрх тэгш байдлын талаар дүн шинжилгээ хийлээ.

Дүн шинжилгээ хийхдээ 1. Жендэрийн шууд агуулгатай /5/, 2. Жендэрийн нөлөөтэй /14/, 3. Жендэртэй холбоогүй /12/, гэсэн 3 хэсэгт хуваан авч үзлээ. Ингэхдээ 1 буюу 2 дахь хэсэгт оруулсан хөтөлбөрүүдийг дотор нь жендэрийн эрх тэгш байдлын 3 үзүүлэлт болох албан ёсны тэгш байдал /8/, бодит тэгш байдал /9/, хамгаалах тэгш байдал /2/ гэсэн 3 бүлэгт хуваан үзсэн.

Үүнээс харахад орон нутгийн нийгэм, эдийн засгийн, хүн амын тулгамдсан асуудлууд, тоон шинжилгээг салбар бүрт нилээд сайн тусгасан ч жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах тогтвортой байдлыг бэхжүүлэх зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлууд бүдэг, орхигдсон гэж үзэж болохоор байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцсэн жендэрийн бодлогыг шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, түүнийг хэрэгжүүлэгчид эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүд, нийгмийн бүлгүүд өөрсдөө ч төдийлөн ойлгож хүлээн авахгүй байгаа нь харагдаж байна.

Хүйсийн тэнцвэрт байдлын хувьд 2018 оны байдлаар нийт 5121 төрийн албан хаагчийн 72.7 хувь нь эмэгтэй, 27.3 хувь нь эрэгтэй, удирдах 456 албан тушаалтны 57.6 хувь нь эмэгтэй, 42.3 хувь нь эрэгтэй, бусад төрийн албан (4665) хаагчдийн 78.49 нь эмэгтэй, 21.51 хувь нь эрэгтэйчүүд байна. Ерөнхий боловсролын салбарт ажиллагсдын 78.5 хувь, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагсдын 97.8 хувь, эрүүл мэндийн салбарын нийт (1448) ажиллагсдын 82.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь эмэгтэй хүйсийн илт давамгайлсан байдал “байна” гэж үзэж болохоор байна.

Үнэлгээний тайланд аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх хэрэгцээ байгааг онцолж, цаашид жендэрийн дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцооны чадавхийг бүрдүүлж, түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага тавигдаж байна гэж дүгнэжээ.

Нөхцөл байдлын үнэлгээний дүнд жендэрийн асуудлыг олон талаас нь үндэслэлтэй харах боломжийг олгох, “Жендэр-ӨВ” дэд хөтөлбөрийг орон нутгийн хүртэгчдэд энгийн байдлаар ойлгуулж, хэрэгжүүлж болохуйц байхаар зорилго, зорилтуудыг тодорхойлох зорилгоор аймгийн хэмжээнд олон талт төлөөллийг оролцуулсан зургаан удаагийн хэлэлцүүлэг хийж, үр дүнг нь хөтөлбөрт тусгасан болно.

Монгол улсын хэмжээнд төдийгүй орон нутгийн хувьд ч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нь аливаа ажлын байранд нас, хүйс зааж, ялгаварлан гадуурхдаг, ажлын байрны дарамт, хүчирхийлэл үзүүлдэг, төрийн захиргааны болон бусад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага, аль ч салбарт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх зөрчигдөж байна гэсэн нийтлэг дүр төрх харагдаж байгаа юм. Түүнчлэн жендэрийн тэгш эрхийн талаарх ойлголт бүх түвшний байгууллага, иргэдэд хангалтгүй байна.

Улсын Их Хурлаас 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаар Жендэрийн үндэсний хорооны салбар хороо аймагт ажиллаж байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны “Эх дэлхийгээ шинэчилье” 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын нийгмийн хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх зорилт, Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичгийн зорилтуудыг тус тус үндэслэн Өвөрхангай аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах “Жендэр-ӨВ” дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү жендэрийн дэд хөтөлбөр нь Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах орон нутгийн онцлогийг харуулсан “Жендэрийн нүдний шил” болох бөгөөд цаашид Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон нийтэд мэдлэг олгох, зөв хандлагыг бий болгох суурь хөтөлбөр болох бөгөөд Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай-2020” хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичгийн зорилт, үйл ажиллагааг дэмжсэн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болно.

Аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.

1. Иргэдийн оршин суугаа газар, нийгмийн байдал, гарал угсаа, нас, хүйс, боловсрол, соёлын ялгаанаас үл хамааран жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой аливаа үйл ажиллагаанд тэгш хамруулах

2. Жендэрийн асуудлаар чадваржсан мэргэжилтнүүдийг бэлтгэн, сургалт, нөлөөлөл, холбогдох үйл ажиллагаануудыг олон нийтэд чанартай хүргэх

3. Орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг ханган ажиллахад, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ), хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, оролцоонд тулгуурласан нээлттэй, ил тод, хариуцлагатай түншлэлийг хөгжүүлэх, сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээх

Хөтөлбөр хэрэгжих хугацаа: 2019-2021 он

Хоёр. Хөтөлбөрийн зорилго:

Нутаг дэвсгэрийн хэмжээнд Жендэрийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэн, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжихэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх

Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.1 Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүд болон бусад бодлого шийдвэрүүдэд жендэрийн эрх тэгш байх зарчмыг зайлшгүй тусгах

1.2. Орон нутгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, салбар хорооноос сум, баг, хороо, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах цагалбар төлөвлөгөө гаргах, удирдамжаар хангах

1.3. Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих

1.4. Жендэрийн эрх тэгш байдлын талаар иргэдийг хүйс, насны онцлогт тохирсон мэдээлэл, сурталчилгаагаар хангах

1.5. Хувийн хэвшлийн байгууллагуудад жендэрийн зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэх, тэдгээрт хүний эрх, жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр шаардлагатай тушаал, захирамж, шийдвэрийг гарган хүргүүлэх, хэрэгжүүлэх

Зорилт 2. Орон нутгийн бодлого, төлөвлөлт, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх

Зорилт 2-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.1. Бүх шатны Засаг дарга, нэгжийн менежерүүдийн үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах

2.2. Байгууллага дотор жендэрийн талаарх мэдлэг ойлголтыг өгдөг, жендэрийн асуудлыг шийдвэрлэн ажилладаг, байгууллагын төлөвлөгөө, орон нутгийн хөтөлбөр, бодлого шийдвэрүүдэд нөлөөлөл хийн ажилладаг байхаар аль нэг мэргэжилтний ажлын байранд тусган хариуцуулах

2.3 Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, эрүүл мэндийн салбарт жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны орчинг бий болгох алхмуудыг хэрэгжүүлэх

2.4.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын дотоод журамд жендэрийн эрх тэгш байдлын асуудлаар байгууллагын онцлогтой уялдуулан холбогдох зохицуулалтыг тусгах

2.5.Төрийн байгууллагын төсөв боловсруулах үүрэгтэй ажилтнуудыг жендэрийн мэдрэмжтэй төсөв хийх сургалтад хамруулах

2.6.Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетыг аймгийн БОЭТөвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжих

Зорилт 3. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх

Зорилт 3-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1 Жендэрийн боловсролыг бүх нийтэд олгох, эрүүл, зөв амьдралын хэвшил, арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран тасралтгүй явуулах

3.2 Гэр бүлийн үнэ цэнийг хувь хүнд ойлгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах

3.3 Иргэдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлэг гаргахад дэмжлэг үзүүлэх

3.4. Төрийн болон ТББ, хувийн хэвшлийн байгууллагууд жендэрийн эрх тэгш байдлыг сурталчилсан мэдээлэл бүхий ном товхимол, гарын авлага, брошур гарган олон нийтэд тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр жендэрийн холбогдолтой мэдээлэл сурталчилгааг хүргэх, сурталчилгааны самбар, мэдээлэл, хуудас байршуулах зэрэг ажлуудыг өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх

Зорилт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхыг бэхжүүлэх, хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах

Зорилт 4-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.1.Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах

4.2.Төрийн алба хаагчдын жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр бэлтгэгдсэн сургагч багш нараар дамжуулан орон нутгийн хувийн хэвшлийн байгууллагуудын бодлого, зорилго, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй болгох чиглэлд нөлөөлөл хийн ажиллах

4.3. Аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр орон нутаг дах төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, үүгээр дамжуулан тэдгээрийн чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Дөрөв. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ.

1. Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавх бэхжсэн байна.
- 3.Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж орон нутагт тогтвортой ажиллана.

Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2018 он)	Хүрэх түвшин		Хариуцах байгууллага
			2019 он	2021 он	
1	Жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сумын тоо /хувиар/	0 хувь	100 хувь	100 хувь	Бүх сум, байгууллага
2	Жендэрийн асуудлыг дотоод журамдаа тусгасан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо (хувиар)	0 хувь	40 хувь	60 хувь	Бүх сум, байгууллага
3	Жендэрийн дэд хөтөлбөрийг	-	10	40	Бүх сум,